

ТӨГСӨГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЭРГЭХ ХОЛБОО

СУИС, ШУТИС, ДБШТ, МУЭИС

Ч. Алтанцэцэг, Доктор (Sc.D.), профессор,
Ш. Бат-Эрдэнэ, доктор (Sc.D.), профессор,
Д. Ариунболор, Доктор (Ph.D.), дэд профессор

Мэргэжилтний боловсролоос улс орны эдийн засгийн өрсөлдөх чадвар шууд хамаарч байгаа энэ цаг үед техник технологийн хөгжил дэвшил, үндэсний уламжлалттай уялдуулан сургалтын дэвшилтэт арга зүйг судлан нэвтрүүлэх, судалгааны дүнд тулгуурлан сургалтын хөтөлбөрийн үр дүнг урьдчилан төлөвлөх, түүнд хүрэх арга зүй, системийг хэрэгжүүлэх, сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн уялдаа холбоог шинэ түвшинд гаргах, мэргэжлийн холбоод бизнесийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах нь боловсролын өнөөгийн хөгжлийн зорилт юм.

Энэхүү илтгэлд их, дээд сургуулийг төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, төгсөгчдийн мэдлэг, чадвар болон ажил олгогчдын шаардлагын хооронд гардаг зөрүү, зарим салбарын хүний нөөцийн судалгаа, их сургуулийн төгсөгчдийн талаар гаргасан судалгаанд үндэслэн тодорхойлсон үр дүнгээс танилцуулав.

Их дээд сургуулиуд нь бүтэц зохион байгуулалт, сургалтын агуулга, арга зүй, чанар үнэлэмжээ дэлхийн жишигт хүргэн шинэчилж, төгсөгчдөд цогц чадамж олгох, нийгэм, эдийн засгийн шинэ сорилтуудыг даван туулах, Монгол улсын ирээдүйг цогцлоох шинэ үеийн хүний нөөцийг бүрдүүлэхийг зорин хөтөлбөрийн үр дүнд суурилсан шинэчлэлийг хийхээр идэвхийлэн ажиллаж байна.

Үр дүнд суурилсан сургалтын систем нь багш нарын мэргэжлийн болон багшлахуйн ур чадвар, сургалтын арга хэлбэр, суралцах орчин нөхцөлийн бүрдэлт, суралцагчийн мэдлэг чадвар, хандлагын үнэлгээ, хөтөлбөрийн үр дүнгийн нэгдсэн үнэлгээний аргачлал бүхий цогц үйл ажиллагаа юм.

Энэ хүрээнд XXI зууны хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэдлэг, чадвар, хандлага бүхий төгсөгчдийг бэлтгэхэд сургалтын хөтөлбөрийн үр дүнг чиглүүлэх, сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг шинэчлэн “үр дүнд суурилсан” сургалтын арга технологийг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэхийн чухлыг тодруулав.

“Дэлхийн боловсрол 2030” хөтөлбөрийг Тогтвортой хөгжлийн зорилтын дөрөвдүгээр зарчмыг хэрэгжүүлэх үйл явцыг НҮБ манлайлан, “Сурч боловсрох нь бүхий л амьдралынхаа туршид эдлэх хүний үндсэн эрх бөгөөд чанартай боловсрол эзэмшихэд хүн бүр тэгш эрхээр хангагдах ёстой” хэмээн тодорхойлон “мэдэхэд суралцах, хийхэд суралцах, оршин байхад суралцах, хамтдаа амьдрахад суралцах” гэсэн дөрвөн тулгуурт зарчмыг мөрдлөг болгож байна¹.

¹ <http://www.unesco.mn/p/45>. "Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development". United Nations – Sustainable Development knowledge platform. Retrieved 23 August 2015.

Их дээд сургуулийг төгсөгч нь ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангах мэргэжилтэн байхаас гадна нийгмийн өмнө үүрэг хариуцлага хүлээх чадвартай, манлайлагч, боловсролтой иргэн байх ёстой.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох барометрын судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-аас жил тутам гаргаж байна. Монгол Улсын Хөдөлмөрийн зах зээлийн дунд ба урт хугацааны таамаглалыг ирэх 10 жилд хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны 19 салбар, мэргэжлийн ангилалын 10 бүлгээр гаргасан байна².

ХНХЯ-наас 2016 онд гаргасан судалгаагаар их дээд сургуулийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт сүүлийн 4 жилд 74,4-80,5% гэсэн судалгаа гарчээ. Хөтөлбөр эрхэлж буй хүмүүсийн 92.5% нь байнгын ажлын байртай, 4,8% түр ажлын байртай, 25,3% нь улирлын чанартай ажил эрхэлдэг гэсэн судалгаа гарчээ³. Тэгвэл 2017 оны ажиллах хүчний эрэлт хэрэгцээний талаарх судалгаагаар шинэ ажлын байр 43000, сул ажлын байр 27600, нийт 70600 ажлын байр хэрэгцээтэй байгааг илрүүлжээ.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын судалгааны институтийн явуулсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар 2016 онд их, дээд сургууль төгсөгчдийн 68.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн 69.6 хувь мэргэжлээрээ ажиллаж байна⁴. Энэ судалгаанаас хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн хамгийн ихээр нэрлэсэн ур чадварын дутагдал нь багаар ажиллах, харилцааны ур чадвар, гадаад хэлний мэдлэг, математик сэтгэлгээ, тооцоолон бодох зэрэг чадварууд байна. Шинэ төгсөгчдийн хувьд ажлын байраа олоход ажлын туршлага байхгүй тул ажил олгогчийн ажлын шаардлагад нийцэхгүй нь түгээмэл гэжээ. Гэтэл тэдэнд туршлага хуримтлуулах боломжийг хэн олгох вэ гэдэг нь ойлгомжгүй байдаг.

Дээд боловсрол олгох хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгч нь

- Шинжлэх ухааны суурь мэдлэгийг сайн эзэмшсэн;
- Шинэ бүтээгдэхүүн, шинэ системийг (технологи) бий болгох, туршин ашиглах үйл ажиллагаанд манлайлан оролцдог;
- Технологийн хөгжил ба судалгаа шинжилгээний ажлын нийгэмд үзүүлэх стратеги нөлөө, ач холбогдлыг бүрэн ойлгож, эзэмшсэн мэргэжилтэн байхыг тухайн боловсролын хөтөлбөрийн үр шимийг хүртэгчид болох төгсөгчөөс гадна эцэг эх, ажил олгогч, нийгэм биднээс шаардаж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн зорилго нь боловсролтой иргэн буюу чадварлаг мэргэжилтэнг хөдөлмөрийн зах зээл, ажил

² “Дунд ба урт хугацааны хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал” Хөдөлмөр, нийгэм хамгааллын судалгааны институт. 2014 он.

³ <http://rilsp.gov.mn/> Сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

⁴ “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2017” Хөдөлмөр, нийгэм хамгааллын судалгааны институт. 2017

олгогч, нийгмийн хүсэл шаардлагад нийцүүлэн бэлтгэхэд оршдог тул нийгэм, эдийн засаг, техник, технологийн ирээдүйн хөгжлийн чиг хандлага, ажлын байрны эрэлт, салбарын бодлоготой уялдуулан, шат шатны байгууллагууд хамтран ажиллах шаардлага зайлшгүй гарч байна.

Дээд боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй томоохон ажлын нэг болох үр дүнд суурилсан боловсролын арга зүйг шат дараатай системтэйгээр нэвтрүүлснээр, нэгдүгээрт техникийн суурь мэдлэгийг бүрэн эзэмшсэн, шинэ бүтээгдэхүүнийг төсөвлөх, төлөвлөх, түүний загварыг нарийвчлан тооцох, үйлдвэрлэлд туршиж судлах, үйлдвэрлэх, удирдах зэрэг бүтээгдэхүүн үйлчилгээний амьдралын мөчлөгийн дэс дарааллыг тодорхойлж чадах өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх, хоёрдугаарт, технологийн хөгжил ба судалгаа шинжилгээний ажлын нийгэмд үзүүлэх стратеги нөлөө, ач холбогдлыг бүрэн ойлгосон, нийгэмшил харилцааны ур чадвартай мэргэжилтнийг бэлтгэж, салбар болон үйлдвэрлэлийн хөгжилд түлхэц өгөх зэрэг “бэлэн мэргэжилтэн”-үүдийг бэлтгэнэ.

Их дээд сургуулиуд боловсролын энэхүү шинэ арга зүйг сургалтандаа нэвтрүүлснээр сургалтын хөтөлбөрийн агуулгыг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн шинэчлэх, шилдэг их дээд сургуулиудын сургалтын арга, технологийг нутагшуулах, хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах, суралцагчдыг идэвхжүүлэх, багшийн заах арга, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, багш оюутны болон хөтөлбөрийн үнэлгээг системтэйгээр хийх, сургалтын чанарыг үнэлэх нөхцөлүүд бүрдэж байгаа юм.

Хөтөлбөрийн зорилго зорилт, суралцахуйн үр дүн хэрхэн төлөвлөгдсөн, түүнд хүрэх сургалтын үйл ажиллагаа маань үр дүнтэй явагдаж байгаа эсэх, төгсөгчийн эзэмшсэн цогц чадамж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцэж буй байдал нь өөрөө шалгуур болдог үр дүнд суурилсан боловсролын арга технологи нь Сургалтын үйл ажиллагааг системтэйгээр зохион байгуулах, суралцахуйн үр дүнг тогтмол үнэлэх, хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах ажлыг ажил олгогч, төгсөгч, суралцагч, багш нарын хамт хийдэг нэгдсэн загвар юм.

Үнэн хэрэгтээ, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хурдац нь шинээр гарч ирэх мэргэжил, түүнтэй холбоотой ур чадваруудыг урьдчилан таамаглах ажлыг хүндрэлтэй болгож байна. Энэ нь илүү уян хатан боловсролын систем бий болгох, хурдацтай өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад мэргэжлийн мэдлэгийг хэрэглэх тал бүрийн ерөнхий дадал чадварыг хөгжүүлэхэд түлхэц болох, ажилтан хүн гадны нөхцөл байдалд илүү уян хатан зохицох, өөрийгөө үр дүнтэй хөгжүүлэх чадвартай, тодорхой мэргэжлийн ажилд шаардлагатай мэргэшлийн ур чадварыг амьдрал дээр хэрэгжүүлэх чадвартай байхыг шаардана.

Манай орны нийгэм, эдийн засгийн практикт байнга шинэ бүтээгдэхүүн, технологи, санаа, шийдэл нэвтэрсээр байна. Хурдацтай нэвтэрч буй мэдлэг оюун үлэмж шингэсэн технологи үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд идэвхигүй оролцдог, мэдлэг хангалтгүй ажилтан бус бүтээлчээр сэтгэдэг, шинэ үеийн техник,

үйлдвэрлэл, үйлчилгээний шинэ технологийг богино хугацаанд чадварлаг эзэмших мэдлэгтэй, идэвхтэй ажилтанг шаардах боллоо.

Энэ бүхний үр дүнд мэдлэг, чадвар, дадлага туршлага дамжуулахад суурилсан уламжлалт сургалт, боловсролын чиг хандлага суралцагсдын бие даасан бүтээлч чадварыг хөгжүүлэх сургалтын тэргүүлэх чиг хандлагаар солигдож байна гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, сургалтын үйл ажиллагаа өндөр бүтээмжтэй хөдөлмөр, шинийг эрэлхийлэх хайлтын боловсролыг хүний амьдралын туршид байнга олгоход чиглэгдэж байгаа юм.

Дээр дурдсан нөхцөл байдлаас үндэслэн дээд боловсролтой мэргэжилтэнг бэлтгэхдээ зөвхөн сургуулийн танхимд лекц, семинарт суулгахаар хязгаарлахгүй эрдэм шинжилгээний байгууллага, пүүс кампани, өндөр технологийн бүтээгдэхүүний зураг төсөл, үйлдвэрлэл эрхлэгч байгууллага дээр практик дадлага хийлгэж, инновацийн мэдлэг олгох сургалт явуулах хэрэгтэй болж байна. Ингэснээр боловсрол, шинжлэх ухаан, инновацийн үйл ажиллагааны (“мэдлэгийн гурвалжин”-гийн) интеграци бий болж эдийн засгийн хөгжил, мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоох шийдвэрлэх хүчин зүйлүүдийн нэг болдог.

Дүгнэлт

1. XXI зууны хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг судалж, шинэ мэргэжлийн хандлагыг тодорхойлох, ойрын ирээдүйд (2030 он) Монголын үйлдвэр, аж ахуйн газруудад шаардлагатай мэргэжилтэн, тэдгээрийн тоо, ирээдүйн шинэ болон одоогийн ажлын байр, мэргэжлүүдийн эрэлтийн талаарх мэдээллээр байнга хангах
2. Дээд боловсролын мэргэшлийн үндэсний хүрээг тодорхойлох хэрэгжүүлэх, ажлын байр, албан тушаалын тодорхойлолтын стандартыг боловсруулж, мөрдүүлэх, үйлдвэр, аж ахуйн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын стандартыг боловсруулж, мөрдүүлэх
3. Төгсөгчдийг ажлын байраар хангах тогтвор суурьшилтай ажиллах, ажлын байран дээр дадлагажихад дэмжлэг үзүүлдэг системийг бүрдүүлэх
4. Үр дүнд суурилсан сургалтын тогтолцоог хөгжүүлж, төгсөгчдийн эзэмшсэн цогц чадамжийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх
5. Их, дээд сургуулиуд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг нэгдсэн арга зүйн дагуу тодорхой хугацаанд, тогтмол хийх
6. Төгсөгчдийн мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх нөхцөл, боломжийг хангахын тулд эргэх холбоог шинэ түвшинд гаргах, төгсөгчдийг хөтөлбөрийн шинэчлэлд татан оролцуулах, тэднийг давтан сургах системийг бүрдүүлэх, төгсөгчдийн холбоогоор дамжуулан сургуулийн хөгжлийн асуудалд хувь нэмэр оруулах